

БАТЛАВ:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020.11.05

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗДТГ-ЫН АЛБАН
ХЭРЭГЦЭЭНД БОХИР СОРОГЧ АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ
ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт ДУГАОНӨГ/202009048
гэрээний дугаар:

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос аймгийн “Говь-Угтаал сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд бохир сорох автомашин” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг ТЭЗҮ хэсэгт хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 11 сарын 16-ны өдрийн 11:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 11 сарын 17-ны өдрийн 11 цаг 10 минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
70593399**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Харьяа татварын хэлтэст өргүй талаарх тодорхойлолт |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэхээр санал болгож автомашины фото зургийг техникийн үзүүлэлт, үнийн хамт маягтын дагуу ирүүлэх 2. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай. 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар 4. Борлуулалтын орлогын хэмжээ: 2019 оны борлуулалт нь 45 сая төгрөгөөс багагүй байх 5. 2019 оны санхүүгийн тайланг ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээс шалгана. 6. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага: 2019 болон 2020 оны аль нэгэнд 25 сая төгрөгөөс багагүй гэрээний үнийн дүн бүхий техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн байх, түүний гэрээ болон хүлээлгэн өгсөн акт 7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон эсэх талаарх харьяа аймаг, дүүргийн шүүхийн тодорхойлолт <p style="text-align: center;">Ирүүлсэн материал тод биш уншигдахгүй бол татгалзах үндэслэл болно.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Огноо: 2020-11-17</p> <p>Цаг: 11:00 цаг хүртэл</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дундговь аймаг, Нутгийн удирдлагын ордон ЗДТГ 3-н давхар 323 тоот өрөө</p> <p>Огноо: 2020-11-17</p> <p>Цаг: 11:10 цаг</p> |


| | |
|----------------|---|
| ТӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй |
|----------------|---|

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** Хавсралтад 01-т автомашин
2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.*
3. **Баглаа, боодол:** -
4. **Бараа хүргэх газар:** Аймгийн Засаг даргын тамгын газар
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ши рхэ г | Хэ мж их нэг ж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|-----------|--|-----------------------|----------------------------|---|--|--------------------------------|--|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэг чийн санал болгосон хугацаа |
| автомашин | Хавсралтад заасан буюу Dongfeng CSL 5060GXWE D5 маркийн бохир сорох автомашинтай дүйцэхүйц | 1 | ш | Аймгийн ЗДТГ | 2020 оны 12 сарын 10 | 2020 оны 12 сарын 15 | |



ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Барааны нэр: Говь-Угтаал сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд бохир соригч автомашин нийлүүлэх

| № | Үзүүлэлт | Хэмжээ |
|----|-----------------------------|---|
| 1 | Загвар | CSL 5060GXWE D5-тай дүйцэхүйц |
| 2 | Төрөл | Бохир соригч |
| 3 | Хөдөлгүүрийн төрөл | 4 цилиндр |
| 4 | Хөдөлгүүрийн багтаамж | 70Kw |
| 5 | Хурдны хайрцаг | 5 шатлалт, механик |
| 6 | Жолооны хурд | Зөв |
| 7 | Шатахууны төрөл | Дизель |
| 8 | Шатахууны зарцуулалт | 10-12л |
| 9 | Гүйлт | 1000 км хүртэл |
| 10 | Суудлын тоо | 2-3 |
| 11 | Баталгаат хугацаа | 1 жил |
| 12 | Монголд орж ирсэн огноо | 2020 он |
| 13 | Үйлдвэрлэсэн он | 2018 оноос дээш |
| 14 | Бохир хураах савны багтаамж | 4м3 дээш |
| 15 | Нэмэлт | Улсын дугаар авч даатгал оношилгоонд хамрагдаж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, татварын гэрчилгээ авсан, түлхүүр багажны иж бүрдэл, дугуйн дорцов болон 1 түлшний шүүр, агаар шүүгч, эхний удаа бүрэн үйлчилгээ хийхэд шаардагдах моторын тос 10л, тосол 25л, задас дугуй 2ш, домкрат, халаагчтай |

Үнийн жагсаалт:

| Д/д | Загвар | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /төг/ | Нийт үнэ /төг/ | Тайлбар |
|-----|-------------------------------|-------------|------------|----------------------|----------------|----------------------------------|
| 1 | CSL 5060GXWE D5-тай дүйцэхүйц | ширхэг | 1 | 45,000,000 | 45,000,000 | Техникийн үзүүлэлтийн дагуу авах |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших**
 - 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
 - 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх**
 - 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх**
 - 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа**
 - 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 12 сараас багагүй байна.
- 6. Гэрээнд өөрчлөлт оруулах**
 - 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
- 7. Төлбөр**
 - 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 8. Бараа нийлүүлэх хуваарь**
 - 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 9. Алданги оногдуулах**
 - 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах**
 - 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
 - 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгаж, туршиж хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <p>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: Нэг 7 хоногт 0.5 <p>Алдангийн нийт дүн:</p> |

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]